

## Монголын Волеиболын Холбооны Европ дахь салбар холбооны дүрэм

### 1. Нийтлэг үндэслэл.

1.1 Монголын Волеиболын Холбооны Европ дахь салбар холбоо нь Европд амьдарч, суралцаж буй монголчууд болон волеиболын спортоор хичээллэж буй хүүхэд залуус спорт сонирхогч ба дэмжигч Монголчуудын хамтын нэгдэл бөгөөд ашгийн бус төрийн бус байгууллага мөн.

1.2 Оноосон нэр : «Монголын Волеиболын Холбооны Европ дахь салбар холбоо . »/Монголоор/  
« Mongolian Volleyball Association in Europe »/Англиар/

1.3 хаяг; Харилцах утасны дугаар : 0032.472.587256 И -майл хаяг : [euro.monvolley@gmail.com](mailto:euro.monvolley@gmail.com)

1.4 Үүсгэн байгуулсан ; 2019 оны 1 сарын 12. Бельги улсын Брюссель хот.Hotel NH.Brussel Louise.

1.5 Эрх зүйн үндэс; Европ дахь монголчууд болон волеиболын спорт сонирхогч хүүхэд залуусыг олж сурвалжилж баг тамирчдыг бүрдүүлэх ахмад тамирчдаас суралцах, туршлага судлах,улс орнуудын спорт клуб, холбоод, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, тэмцээн уралдааны талаар нэгдсэн мэдээ мэдээллээр хангах, тэмцээн зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар чиглүүлэх болон Монголын Волеиболын холбоотой хамтран ажиллах эрх бүхий байгууллага байна. «Монголын Волеиболын Холбооны Европ дахь салбар холбоо нь Монголын волеиболын холбооны гишүүн байгууллага бөгөөд, Европ дахь болон Хилийн чанад дахь монголчуудын бусад ТББ- уудтай Монголын волеиболын холбоог төлөөлөн үйл ажиллагаа явуулж волеиболын спортоо сурталчилна. Лого тамга facebook хуудас болон гишүүнчлэлтэй байна.

1.6 Үндсэн зарчим; Монголын Волеиболын Холбооны Европ дахь салбар холбоо нь дараахь үндсэн зарчимуудыг удирдлага болгоно: а.Салбар холбоо нь Монголын волеиболын холбооны гишүүн байгууллага байна. b.Салбар холбоо нь спортоор хичээллэгч сонирхогч дэмжигч хэсгийн нийтлэг эрх ашгийг төлөөлнө. c. Үйл ажиллагаагаа гишүүд дэмжигчдийн гаргасан санал санаачлага дээр үндэслэн явуулна. d. Үйл ажиллагаагаа хараат бус бие даасан байдлаар явуулна. e.. Үйл ажиллагаа нь олон нийтэд нээлттэй ил тод байна f. Салбар холбоо нь үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж болон Монголын волеиболын холбооны дүрмийг удирдлага болгоно. g.Салбар холбоо нь хуулийн этгээд бөгөөд лого, албан бичгийн хэвлэмэл хуудас,тамга тэмдэг, веб хуудас, гишүүнчлэлтэй байна.

### 2. Хоёрдугаар зүйл

2.1 Зорилго Европын монголчуудаа спортын талбарт ойртон танилцуулж, волеиболын спортоор хичээллэх сонирхол төрүүлэх, хүүхэд залуусыг уриалан дуудах, олж сурвалжилж баг тамирчдыг бүрдүүлэх,улс орнуудын спорт клуб, холбоод, төрийн бус байгууллагуудтай холбоо тогтоож, нэгдсэн мэдээ мэдээллээр хангах, тэмцээн уралдаан зохион байгуулах, харилцан суралцах, нэгдсэн удирдлагаар чиглүүлэх болон биеийн тамир спортыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой.

2.2 Үйл ажиллагааны чиглэл Спорт сонирхогч Европын монголчууд ба хилийн чанад дахь монгол волеиболчид,Монголын Волеиболын Холбооны хамтын ажиллагааг холбох гүүр болж ажиллана.

2.2.а Европын улсуудад волеиболын спортоор сонирхон хичээллэж амжилт гаргаж яваа өсвөр үеийн хүүхэд залуучуудыг олж сурвалжилж, урамшуулан дэмжих

2.2б. Европын монголчуудын волеиболын аварга шалгаруулах тэмцээнийг нэгдсэн мэдээ мэдээллээр хангах зохион байгуулагч оронтой хамтран ажиллах 2.2.в Хилийн чанад дахь

монголчууд, баг тамирчид, клуб, холбоод хоорондоо болон бусад гадаад багуудтай хамтарч тоглох, туршлага солилцох боломжийг судалж холбож өгч байх

2.2г. Энэ талаархи мэдээ мэдээллийг Монголын Волеиболын Холбоо болон монголын холбогдох спортын байгууллагуудад өгч хамтарч ажиллах

2.2.д. Европын монголчуудын дундах волеиболын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулалтын хувьд удирдлагаар хангаж нэгдсэн дүрэм журам дагаж буйд хяналт тавих

2.2е. Монгол орноо сурталчлах, монголчуудаа ойртуулан танилцуулах боломжыг хангах.

Гуравдугаар зүйл

### 3.1 Гишүүнчлэл

Салбар холбоонд зорилго үзэл санаа, үйл ажиллагааг нь хүлээн зөвшөөрсөн дэмжиж буй хүмүүс элсэн орж болно. Гишүүнчлэл 3 төрөлтэй байна

а) Энгийн гишүүн : сонирхон хичээллэгч дэмжигчсэд

б) Гишүүн баг; хамт олон

в. Хүндэт гишүүн;

### 3.2 Гишүүн элсүүлэх

а. Гишүүн элсүүлэх ажлыг УЗ хариуцаж гишүүний бүртгэл хөтөлнө.

б. Энгийн гишүүн нь гишүүн болох хүсэлтээ анкет бөглөж ирүүлсний дагуу гишүүнчлэлийн татвар төлж үнэмлэх авна.

в. Санал өгөх нэр дэвших эрхтэй болно

г. Хүндэт гишүүн.

Салбар холбооны үйл ажиллагааг дэмжиж ажилладаг хандив өргөдөг хувь хүн байгууллага хүндэт гишүүн болж болно.

д. Хүндэт гишүүн, гишүүний хураамж төлөхгүй, саналын эрх эдлэхгүй

е. Гишүүн баг багаараа гишүүнчлэлд элсэн орно. Татвараа багаараа жилд 1 удаа төлнө

### 3.3. Гишүүдийн эрх үүрэг, хариуцлага.

а) Гишүүд нь салбар холбооноос явуулж буй үйл ажиллагаанд эрх тэгш оролцох, мэдээлэл авах эрхтэй.

б) Санал өгөх нэр дэвших эрхтэй Хуралд хэлэлцэх асуудалд хүсэлт гаргах, санал оруулах эрхтэй.

с) Үр бүтээлтэй ажиллаж спортын өндөр амжилт гаргасан тамирчин нэр хүндийн урамшуулал сайшаал магтаал хүртэх эрхтэй.

д. Гишүүнчлэлээс татгалзах, эсвэл дүрэм зөрчсөн тохиолдолд УЗ хэлэлцэж зохих шийдвэр гаргана.

### 3.4 Гишүүний үүрэг.

а. Салбар холбооны үйл ажиллагааг дэмжиж идэвх санаачлагатай байна.

б.Тухайн орондоо явагдаж байгаа тэмцээн болон Европын монголчуудын волейболын аварга шалгаруулах тэмцээнд баг бүрдүүлэн оролцох бэлтгэл сургууль хийхэд идэвхтэй туслаж дэмжих

в.Волейболын спортын шинэ тутам гарч буй мэдээ мэдээллийг бусдад мэдээлж дамжуулж хуваалцах Дөрөвдүгээр зүйл.

4.1.Монголын волейболын холбооны Европ дахь салбар холбооны эрх,

а.МВХ -ны Европ дахь салбар холбоо нь бие даасан хараат бус байдлаар үйл ажиллагаагаа явуулах эрхтэй.

б.Волейболын спортыг хөгжүүлэх тэмцээн уралдаан зохион байгуулах талаар МВХ болон бусад холбогдох байгууллагуудад санал хүсэлт хүргүүлэн шийдвэрлүүлэх эрхтэй.

в.Мэргэжлийн багш дасгалжуулагч урьж хамтран ажиллах мэргэжлийн арга туршлага зөвлөлгөө авах эрхтэй.

с. Европын монголчуудын волейболын аварга шалгаруулах тэмцээнд тогтмол оролцож удаа дараа амжилт гаргасан тамирчдыг зэрэг цолд дэвшүүлэн уламжлах

д. Европын монголчуудын волейболын аварга шалгаруулах тэмцээн хэзээ хаана болохыг УЗ гишүүд ярилцаж шийдвэрлэх эрхтэй.

4.2. Үүрэг;

а.Европын монголчуудын дунд волейболын спортыг дэлгэрүүлэн хөгжүүлэх сурталчлах бодлого боловсруулж МВХ -ны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх,

б...Европын монголчуудын волейболын аварга шалгаруулах тэмцээнд мэргэжлийн алба дасгалжуулагч нар хяналт тавиж ажиллах

в.Орон оронд клуб спорт холбоод үүсэн ажиллахыг дэмжин ажиллах. г.Залгамж холбоо өсвөрийн хүүхэд залуусыг олж сургах зааж зааварлах үүрэгтэйгээр ажиллах Тавдугаар зүйл.

5.1Удирдлага зохион байгуулалт

5.2. Салбар зөвлөлийн дээд удирдлага нь Хурал.

а.Хурлыг Европын монголчуудын аварга шалгаруулах тэмцээн болж байгаа тухайн оронд хийнэ.

б..Тэмцээний ерөнхий зохион байгуулагч чуулган хийх байрыг хариуцаж бэлдэнэ.

в...Хурлаар дараах асуудалыг хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэнэ :

--Салбар холбооны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах :

-- УЗ гишүүдийг томилох эргүүлэн татах

--Хяналтын албаны гишүүдийг томилох эргүүлэн татах

-- Өмнөх жилийн тэмцээний ололт амжилт алдаа дутагдлын талаар танилцуулж зохих шийдвэр ярилцана.

-- Ирэх жилийн тэмцээн дээр нэмэгдэх зүйлүүдийг тогтож батлах

5.3Удирдах зөвлөл

а) Хурлын хооронд салбар холбооны эрх барих байгууллага нь УЗ байна.

b) УЗ нь 11-ээс доошгүй гишүүдээс бүрдэнэ.

с) УЗ гишүүдийг чуулганд оролцсон гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

d) УЗ гишүүний бүрэн эрхийн хугацаа 2 жил байх бөгөөд улиран сонгогдож болно.

e. яаралтай шийдэх асуудалтай үед УЗ онлайн хуралдаж шийдвэр гаргана.

#### 5.4.УЗ бүрэн эрх.

Салбар холбооны бодлого зорилтыг тодорхойлно.

Хөтөлбөр төлөвлөгөө боловсруулж хурлаар хэлэлцүүлж батлуулна. Улс орнуудаас 2-3 хүн УЗ-д ажиллах бөгөөд тэмцээнд тухайн орноо төлөөлөн баг тамирчдаа бүрдүүлж оролцох мэдээ мэдээллээр хангаж идэвхтэй ажиллана. Бусад ТББ-уудтай хамтран ажиллана.

Гишүүний хураамжийг хураах хэмжээг тогтоох

Тэргүүнийг сонгох, түүний үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллана.

УЗ гын НБ- ииг Тэргүүний санал болгосноор томилно.

УЗ гишүүд нь салбар зөвлөлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд шаардлагатай хуримтлал босгох, нэмэгдүүлэх тал дээр идэвхи санаачлагатай ажиллах.

УЗ гишүүд нь холбооны зорилго, хөтөлбөр үйл ажиллагааг сайн дураар дэмжин ажиллах ба ямарваа цалин хөлс авахгүй.

#### 5.5 Удардах зөвлөлийн гишүүдийг чөлөөлөх.

УЗ гишүүн нь биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар үүрэгт ажилаа гүйцэтгэх боломжгүй болсон бол УЗ Хурлаар оруулж шийднэ.

Зургадугаар зүйл

#### 6.1 Салбар холбооны тэргүүн

Өдөр тутмын үйл ажиллагааг Тэргүүн удирдах ба дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ :

1. Салбар зөвлөлийг төлөөлж бусад холбоод ТББ, Монголын волейболын холбоотой харилцах

2. УЗ болон үйл ажиллагааг уялдуулж, хяналт тавина.

3. УЗ хуралыг даргалах

4. УЗ эрх болгосноор салбар зөвлөлийг төлөөлж гадаад дотоодын аливаа байгууллагатай гэрээ хийх, хэлэлцэн тохирно.

5. Тэргүүний бүрэн эрхийг түүний зөвшөөрөлтэй нарийн бичиг орлон гүйцэтгэнэ.

6.2 жилд 1 удаа болох хурлаар тайлангаа тавиж мөрийн хөтөлбөрөө танилцуулна.

Долдугаар зүйл

Мэргэжлийн алба;

МА нь 3 хүний бүрэлдэхүүнтэй байна.

МА нь салбар зөвлөлийн үйл ажиллагаанд явагдах тэмцээн уралдаанд хяналт тавьж ажиллах мэргэжлийн чиг баримжаа өгч хамтарч ажиллах тэмцээний дүрэм журмыг сахиулах мөрдүүлэхэд

анхаарах шинээр гарч байгаа холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг танилцуулж мөрдүүлэх сургалт семинар зохион байгуулах үүрэгтэй.

Наймдугаар зүйл Санхүү төсөв.

Салбар холбооны үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ :

1. Гишүүдийн хураамж
2. Хандив, тусламж
3. Тэтгэлэг
4. ЭСЯ (улсын төсөв )